



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

Хорооны 2009 оны 276 дугаар тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 276 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлд дор дурьдсан агуулгатай 5, 6, 7, 8 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 2 дугаар зүйлийн 2.5, 2.6, 2.7, 2.8 дахь заалтууд:

“2.5. Энэ журмын 2.1-д заасан нөөц сан нь даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сангаас бүрдэнэ.

2.6. Даатгалын багц бүтээгдэхүүнийг нөхцөл тус бүрээр задалж нөөц сангийн тооцооллыг хийнэ.

2.7. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо даатгагчийн мөрдөж байгаа насжилтын хүснэгтэд үндэслэнэ. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг энэ журмын 3.2-т зааснаар тооцно.

2.8. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна.”

2. Мөн журмын 2.3, 5.2 дахь заалтуудыг доор дурьдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “2.3. Даатгагч нь нөөц санг цэвэр хураамжийн орлого болон хөрөнгө оруулалтын орлогоос бүрдүүлэх бөгөөд цэвэр хураамжийн орлогыг даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалд төлсөн хураамжийг хасч тооцно.”

2/ “5.2. Хорооноос эрх авсан актуарч нь даатгалын нөөц сангийн тооцооллын тайланг энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар, нөөц сангийн бүрдүүлэлтийн тайланг хоёрдугаар хавсралтаар тус тус улирал бүр гаргаж Хороонд ирүүлнэ.”

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000575